

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 24 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2024-11

Улаанбаатар хот

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний
хөлсийг шинэчлэн тогтоох тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.4 дэх хэсэг болон 8.6 (v) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-10 дугаар тогтоолоороо ТУЗ-ийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоох тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
- Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн зөвлөмжийн дагуу ТУЗ-ийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- ТУЗ-ийн даргаас бусад гүйцэтгэх удирдлагын бус ТУЗ-ийн гишүүний хөлсийг дараах байдлаар тогтоосугай:
 - Жилд олгох нийт хөлсийг 50,000 (тавин мянга) ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоож улирал тутам тооцож олгосугай. Энэхүү өөрчлөлтийг 2024 оны санхүүгийн жилээс эхлэн мөрдсүгэй.
 - ТУЗ-ийн дэргэдэх нэг болон түүнээс дээш хороодын даргаар ажиллаж буй гишүүн бүрд жилд олгох нийт 5,000 (таван мянга) ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн нэмэгдлийг хэвээр тогтоож, 2024 оны санхүүгийн жилд үргэлжлүүлэн мөрдсүгэй.
- Энэхүү шийдвэрийн дагуу ТУЗ-ийн гишүүний хөлсийг 2024 оны санхүүгийн жилээс эхлэн шинэчлэн тогтоож, ийнхүү тогтоосонтой холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн SR-2022-04 дүгээр тогтоолын 1 болон 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА